



ӨВӨРХАНГАЙ АЙМАГ  
ТАТВАРЫН ХЭЛТСИЙН ДАРГЫН  
ТУШААЛ

2022 оны 04 сарын 26 өдөр

Дугаар 4/29

Арвайхээр

Хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5 дахь заалт, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.4 дэх хэсэгт, Татварын хэлтсийн "Хөдөлмөрийн дотоод журам"-ын 13.2.6 дахь заалтуудыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Байгууллагын ажилтан албан хаагчдын дунд эрүүл агаар-явган аялал, спортын өдөрлөгийг батлагдсан төлөвлөгөөний дагуу Өвөрхангай аймгийн Засаг даргын тамгын газраас зохион байгуулж буй "Илүүдэл жингүй-Эртэч монгол" уриатай 4 байгууллагатай хамтарсан аяны удирдамжийг 1 дүгээр хавсралтаар, өглөөний дасгалын цагаар "Гэгээн өглөө"-г амттай, аялгуутай, инээмсэглэн угтая уриатай хөтөлбөрийг 2 дугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. "Илүүдэл жингүй-Эртэч монгол" уриатай 4 байгууллагатай хамтарсан аяны зарцуулагдах 100,000 (Нэг зуун мянган) төгрөг, өглөөний дасгалын хөтөлбөрт сар бүр зарцуулагдах 200,000 (Хоёр зуун мянган) төгрөгийг нэмэлт санхүүжилтийн нэг удаагийн тэтгэмж, урамшууллын зардлаас гаргахыг нягтлан бодогчийн албан үүргийг түр орлон гүйцэтгэгч (С.Отгонлхагва)-д зөвшөөрсүгэй.

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР  
ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ Н.ЭРДЭНЭСУВД

